

“МОННООС”  
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

---

2024 оны 4-р сарын 29-ны өдөр

Дугаар 01/24

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн саналын  
дүнг батлах тухай

Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 63 дугаар зүйлийн 63.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Монноос” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01/24 тоот тогтоол, хувьцаа эзэмшигчдийн хурлын Т-01/24 тоот тэмдэглэлийн шийдвэр хэсгийн 1 дүгээрт заасныг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын 174,556 санал буюу 78,1%-ийн саналаар Компанийн 2023 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг баталсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, “Компанийн тухай хууль”-ийн 83 дугаар зүйлд заасан эрх үүргийг хэрэгжүүлж, компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, ТУЗ-д сар бүр ажлаа дүгнүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Х.Эрдэнэбаяр/-д үүрэг болгосугай.

Хурлын дарга

Тооллогын комиссын дарга



Х.Эрдэнэбаяр

Л.Пүрэвхүү

“МОННООС”  
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 4-р сарын 29-ны өдөр

Дугаар 02/24

Улаанбаатар хот

Компанийн удирдлагыг сонгож  
батлах тухай

Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дугаар заалт, “Монноос” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01/24 тоот тогтоол, ХЭХ-ын Т-01/24 тоот тэмдэглэлийн шийдвэр хэсгийн 2 дугаарт заасныг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн  
174,556 кумулятив санал буюу 78,1%-ийн саналаар С.Мөнхжаргалыг,  
174,556 кумулятив санал буюу 78,1%-ийн саналаар Д.Мөнхбатыг,  
174,556 кумулятив санал буюу 78,1%-ийн саналаар С.Алимааг,  
174,556 кумулятив санал буюу 78,1%-ийн саналаар Ж.Болбаатарыг,  
174,556 кумулятив санал буюу 78,1%-ийн саналаар П.Оюунбаярыг тус тус  
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн энгийн гишүүнээр,  
174,556 кумулятив санал буюу 78,1%-ийн саналаар Билл Холдсвортыг,  
174,556 кумулятив санал буюу 78,1%-ийн саналаар Б.Мэдрээг,  
174,556 кумулятив санал буюу 78,1%-ийн саналаар И.Сэр-Одыг,  
174,556 кумулятив санал буюу 78,1%-ийн саналаар О.Алтангэрэлийг тус тус  
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосныг тус тус баталсугай.
2. “Компанийн тухай хууль”-ийн 76 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж,  
компанийн үйл ажиллагааг удирдлага хяналтаар хангаж ажиллахыг Төлөөлөн  
Удирдах Зөвлөлийн дарга /Билл Холдсворт/-д зөвшөөрсүгэй.

Хурлын дарга

Тооллогын комиссын дарга



Х.Эрдэнэбаяр

П.Пүрэвхүү

“МОННООС”  
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 4-р сарын 29-ны өдөр

Дугаар 03/24

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах ТУЗ-ийн  
шийдвэрийг дэмжих тухай

“Компанийн тухай хууль”-ийн 46 дугаар зүйл, компанийн ногдол ашгийн бодлогын тухай журам, ТУЗ-ийн 2024 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн 02/24 тоот тогтоолоор гаргасан шийдвэр, хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01/24 тоот тогтоол, хувьцаа эзэмшигчдийн хурлын 01/24 тоот тэмдэглэлийн шийдвэрлэсэн нь хэсгийн 3 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн удирдлагын зардлын төсвийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын 174,556 санал буюу 78,1%-ийн саналаар 2023 оны ногдол ашгийг нэгж хувьцаанд 65 төгрөгөөр тогтоосон ТУЗ-ийн 02/24 тоот тогтоолыг дэмжсүгэй.
2. Ногдол ашигт зарцуулагдах 22,807,005 төгрөг /Хорин хоёр сая найман зуун долоон мянга таван/-ийг компанийн ашгаас гаргахыг Гүйцэтгэх захирал /Х.Эрдэнэбаяр/-т зөвшөөрсүгэй.
3. Компаниас гаргах мөнгөн хөрөнгийг 2024 оны 5 дугаар сарын 31-ны дотор Ногдол ашигийг нийтэд зарлан, тараах ажлыг зохион байгуулан гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал /Х.Эрдэнэбаяр/-т даалгасугай.

Хурлын дарга

Х.Эрдэнэбаяр

Тооллогын комиссын дарга

П.Пүрэвхүү



“МОННООС”  
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 4-р сарын 29-ны өдөр

Дугаар 04/24

Улаанбаатар хот

Компанийн удирдлагын зардлыг  
батлах тухай

“Компанийн тухай хууль”-ийн 62.1.13 дугаар зүйл, хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01/24 тоот тогтоол, хувьцаа эзэмшигчдийн хурлын 01/24 тоот тэмдэглэлийн шийдвэрлэсэн нь хэсгийн 3 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн удирдлагын зардлын төсвийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын 174,556 санал буюу 78,1%-ийн саналаар 4,200,000 төгрөг /Дөрвөн сая хоёр зуун мянган/-өөр баталсугай.
2. Батлагдсан төсөвт багтаан компанийн удирдлагын зардлыг санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал /Х.Эрдэнэбаяр/-д, зардлын зарцуулалтын үнэн зөв байдалд хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллахыг ТУЗ-ийн дарга /Билл Холдсворт/-д тус тус даалгасугай.

Хурлын дарга

Тооллогын комиссын дарга



Х.Эрдэнэбаяр

Л.Пүрэвхүү